



ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/62

Даланзадгад

Төрөлжсөн мэргэжлийн баг байгуулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийг 12.1.4 дэх заалт, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/304, А/699, А/460 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 3.3.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цогц үзлэг шинжилгээ хийх төрөлжсөн мэргэжлийн багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, багийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цогц үзлэг хийх нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж, тушаалын батлагдсан маягтын дагуу бүртгэж, хувийн хэрэг хөтлөн хэрэгжилтийг хангаж, тайланг холбогдох байгууллагад тайлагнаж байхыг багийн ахлагч /М.Цэндсүрэн/-д даалгасугай.

3. Төрөлжсөн мэргэжлийн багийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтэс /Б.Мидэрсүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ӨНӨРЖАРГАЛ

Эрүүл мэндийн газрын даргын  
2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн  
А/62 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД ЦОГЦ ҮЗЛЭГ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ  
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:**

Багийн ахлагч: М.Цэндсүрэн- Эрүүл мэндийн газрын Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Багийн гишүүд:

- Т.Оюундүү- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хүүхдийн зөвлөх эмч
- Т.Өлзийсайхан- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэдрэлийн зөвлөх эмч
- Л.Өсөхжаргал - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сэтгэцийн эмч
- Л.Сарантуяа- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн чих хамар хоолойн эмч
- Ц.Мөнхцэцэг- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн нүдний эмч
- П.Мөнгөнчөдөр- Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын сэтгэл зүйч
- М.Жаргал -Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын мэргэжилтэн
- Өрх, сумын эмнэлгийн дарга нар

Багийн нарийн бичгийн дарга: Амартүвшин- Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын даргын  
2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн  
А/62 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД ЦОГЦ ҮЗЛЭГ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛИЙН БАГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Төрөлжсөн мэргэжлийн багийн зорилго нь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд тодорхой зорилтот насны хүүхдэд нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээ, оношилогоо хийх, түүний гэр бүлд нь мэргэжлийн зөвлөгөө өгч дэмжлэг үзүүлэх, анхан шатны эрүүл мэндийн байгууллага болон цэцэрлэг, боловсролын байгууллагуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чадавхийг нэмэгдүүлэхэд оршино.

Төрөлжсөн мэргэжлийн багийн үйл ажиллагаа:

Хөгжлийн хоцрогдолтой хүүхдийг эрт илрүүлэх, оношилох, тусламж үзүүлэх зорилгоор тодорхой зорилтот насанд жилд 1-ээс доошгүй удаа цогц үзлэг шинжилгээг зохион байгуулна.

Хөгжлийн хоцрогдолтой хүүхдийн нэгдсэн судалгааг гаргаж, цогц үзлэгийг хийж оношилно. /Анх үзлэг хийсэн эмч нь шаардлагатай тохиолдолд багийн гишүүдээс холбогдох мэргэжилтэнтэй хамтран үнэлгээ хийж оношийн талаар зөвлөлдөнө/

Багийн гишүүдээр зөвлөлдсөнөөр эцсийн оношийг тогтооно. Тохиолдол бүрт бүх гишүүд цугларах шаардлагагүй. /Жишээ: Сонсголын асуудалтай бол зөвхөн сонсголын бичлэг хийж дүгнэлт гарган Аймгийн ЭХМК-д илгээж болно/

Өвчний оношийг олон улсын 10 дугаар ангилал (ICD-10)-ын дагуу тавьж, өвчин эмгэг, хөдөлмөрийн чадвар алдалт, сонсгол, харааны зэрэг, танин мэдэхүйн хоцрогдол, бие эрхтний хөгжлийг ерөнхийд нь үнэлж, хүүхдэд шаардлагатай тусламж үйлчилгээ, эмчилгээг тогтооно/

Өрх, сумын ЭМБ-ын ажилтантай уулзаж шаардлагатай мэдээллийг авч болно.

Шаардлагатай хүүхдэд эмнэлгийн дүгнэлт гаргаж, тухайн эрүүл мэндийн байгууллагын эмчлэгч эмч, эрхлэгчийн гарын үсэгтэйгээр аймгийн ЭХМК-д илгээнэ.

Зайлшгүй шаардлагатай, хүүхэд өөрөө биеэр ирэх боломжгүй зэрэг шалтгаантай бол аймгийн ЭХМК-ын хуралдаанд холбогдох материалыг оруулж мэдээлэл өгнө.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч нарт хүүхдэд өгөх зөвлөгөө, дэмжлэгийг үзүүлнэ.

Салбар комисст илгээх шаардлагагүй зөвхөн сэргээн засалт, эмийн эмчилгээ, шинжилгээ шаардлагатай хүүхдийг холбогдох мэргэжилтэнд илгээж болно.